



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/88

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 06 дугаар зөвлөмжийн дагуу Залуучуудын усан спортын цогцолборын барилга угсралтын ажлын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээг 130956418 (нэг зуун гучин сая есөн зуун тавин зургаан мянга дөрвөн зуун арван найман) төгрөгөөр "Балданс" ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

1. Гэрээ байгуулж, зураг төсөв боловсруулах явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

2. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100205